

**АШУУИС-ИЙН ДОРНОГОВЬ САЛБАР АУС-ИЙН БАГШ НАРЫН “ЭРДМИЙН БАГА
ЧУУЛГАН-2018” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ТАЙЛАН**

2018.03.29

САЙНШАНД

“БАГШ НАРЫН ЭРДМИЙН БАГА ЧУУЛГАН-2018” эрдэм шинжилгээний хурал нь 2018 оны 03 сарын 28-ны өдөр АШУУИС-ийн Дорноговь салбар АУС-ийн “Соёлын танхим”-д илтгэл, бүтээлийн хэлэлцүүлгийн хуралдаанаар зохион байгуулагдлаа.

Тус хуралд нийт 17 илтгэл ирснээс 12 илтгэл нь аман хэлбэрээр, 1 илтгэл нь ханан хэлбэрээр хэлэлцэгдлээ.

Хурлын үйл ажиллагаанд АШУУИС-ийн дорноговь салбар АУС-ийн захирал, АУ-ы доктор, дэд профессор Ц.Цабшир, СБЗГ-ын дарга АУ-ы магистр Д. Сансармаа болон сургуулийн нийт 52 багшаас гадна “Амар Оюуны Хөрөнгө Оруулалт” ХХК-н гүйцэтгэх захирал, Ц.Сайханаа, Дани улсын Копенгаген хотын “Global Nutrition and Health” их сургуулийн оюутан Marlene, Becky нар оролцов.

Эрдэм шинжилгээний хурлын өмнө “Амар Оюуны Хөрөнгө Оруулалт” ХХК-н гүйцэтгэх захирал Ц.Сайханаа “Эерэг хандлагыг бүтээх нь” сэдэвт сургалтыг мөн Дани улсын Копенгаген хотын “Global Nutrition and Health” их сургуулийн оюутнууд болох Marlene, Becky нар “Public health & Nutrition” сэдэвт лекц, сургалтыг сургуулийн нийт баш ажилчдад уншиж сонордуулав.

Хурлын шүүгчээр Биологийн ухааны доктор Д.Баатар, АУ-ы доктор Б.Наранцэцэг, АУ-ы доктор Н.Ариунжаргал нар ажилласан бөгөөд шагналт байранд орсон багш нарыг дурдвал:

- Тэргүүн байранд “Эмч эмнэлгийн мэргэжилтний цогц чадамжид үйлчлүүлэгчдийн өгсөн үнэлгээ” сэдэвт илтгэлээр АУ-ы магистр Г.Энхцэцэг
- Дэд байранд “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинг судалсан нь” сэдэвт илтгэлээр НЭМ-ийн магистр Ц.Даваачимэг
- Гутгаар байранд “Оюутнуудын сэтгэл хөдлөлөө удирдах когнитив стратегийг судлах нь” сэдэвт илтгэлээр АУ-ы доктор Х.Удвал нарыг тус тус шалгаруулан өргөмжлөл, мөнгөн шагналаар шагналаа.

Шагналыг АШУУИС-ийн дорноговь салбар АУС-ийн захирал, АУ-ы доктор, дэд профессор Ц.Цабшир, СБЗГ-ын дарга АУ-ы магистр Д.Сансармаа нар гардуулж судлаачдын цаашдын бүтээлд амжилт хүсэн хурлын үйл ажиллагааг 20 цаг 30 минутанд хаалтын үйл ажиллагааг дуусгав. Хуралтай холбоотой зургийг хавсаргасан болно.

Тайлан бичсэн: Гадаад Харилцаа Багшийн Хөгжлийг Дэмжих тэнхмийн эрхлэгч: П.Батчимэг

